

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Энэ сард Төрийн шагналаар шагнуулахаар тодорхойлсон Өлгий сумын нэг иргэний материалыг хүлээн авч танилцан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмын дагуу баримт бичгийг хянан шалгаж, материалыг Барилга, хот байгуулалтын яаманд уламжлан ажилласан.

Засгийн газрын "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хөтлөлт"-ийн улсын үзлэг явуулах тухай 2019 оны 150 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хөтлөлтийн улсын үзлэгийн ажлын хэсэг тус аймагт ажиллаж аймгийн хэмжээнд 93%-тай үнэлэгдэв.

Аймагт нүүрсний үнэ нэмэгдэж иргэдийн гарт очих нэг тонн нүүрс 90-100 мянган төгрөгт хүрч, иргэдээс үнийн тогтворжуулалт хийх талаар гомдол ирүүлсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Засаг даргын орлогч А.Камелиятаар ахлуулсан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөл 2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр хуралдаж, холбогдох байгууллагууд болон "Хотгор" компанийн удирдлага, нүүрс тээвэрлэж худалдан борлуулдаг иргэд, жолооч нартай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахаар шийдвэр гаргасан ба үүний хүрээнд 9 дүгээр сарын 18-ны өдөр аймгийн ЗДТГ-ын хурлын зааланд аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын орон нутаг дахь Улсын ахлах байцагч болон Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн эрх бүхий албан тушаалтнууд "Хотгор" компанийн удирдлага, нүүрс тээвэрлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй уулзаж талууд нэг тонн шигшүүрээр ялгасан нүүрсний үнийг тонн тутам 75 мянган төгрөгөөр баталгаажуулсан жингээр борлуулахаар тохиролцоонд хүрэв.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2.1. Хууль хяналтын үйл ажиллагаа

2.1.1. Хууль, эрх зүйн хэлтсийн мэдээлэл

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нь аймгийн Засаг даргын 9 дүгээр сарын 85 ширхэг А захирамжийг хянав.

Хууль, эрх зүйн хэлтсийн хууль тогтоомжийн лавлах санд хууль, УИХ-ын болон Засгийн газрын тогтоол, эрх зүйн хэм хэмжээний актыг шинээр бүртгээгүй ба иргэдээс амаар болон бичгээр гаргасан хүсэлт, өргөдлийг хүлээж авч, 6 хүнд зөвлөгөө өгч үйлчлэв.

Мөн Согтууруулах ундаа худалдах нөхцөл, шаардлагыг хангаж, улсын тэмдэгтийн хураамж төлсөн 1 дэлгүүрт болон 1 үйлчилгээний газарт спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар сунгаж зөвшөөрөл олгов.

2.1.2. Шүүхийн шинжилгээний албаны мэдээлэл

№	Үзүүлэлт	Тухайн сар	Өссөн дүн
1.	Криминалистикийн шинжилгээний тоо	10	59
2.	Хэргийн газрын үзлэгт оролцсон тоо	22	220
3.	Гутлын мөр	3	39
4.	Тээврийн хэрэгслийн мөр	5	50
5.	Эвдлэгч багажийн мөр	0	7
6.	Биологийн гаралтай ул мөр	1	9
7.	Бусад ул мөр	15	141
8.	Хонгио хошуу	-	69
9.	Гарын дардас	1	99
10.	Гарын мөр	6	26
11.	Шүүх эмнэлгийн хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоо	42	428
12.	Шүүх эмнэлгийн бэлгийн холбогдолтой шинжилгээний тоо	1	7
13.	Цогцост хийсэн шинжилгээний тоо	5	33
14.	Тусгай шинжилгээ болон химийн шинжилгээний тоо	13	84

2.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл (Өссөн дүнгээр)

№	Заалт	Биелэлт, хувь, тоо
1	Цагдаагийн газрын нийт хүлээн авсан гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдол мэдээлэл	2186
2	Бүх гэмт хэрэг	233
3	Гэмт явдлын улмаас гэмтсэн	78
4	Гэмт хэргийн улмаас нас барсан хүн	11
5	Малын хулгайн гэмт хэрэг	5
6	Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг	39
7	Нийт учирсан хохирол /сая.төг/	714,2 буюу 562,6 сая төг
8	Баривчлагдсан хүн	167
9	Зөрчлийн хуулиар хэдэн хүнийг хэдэн сая төгрөгөөр торгож, арга хэмжээг авч ажилласан байдал	9626 хүнийг 389175,5 төгрөгөөр торгож.
10	Камераар илрүүлсэн зөрчил	954
11	Саатуулагдсан хүний тоо	620
12	Нийт зөрчил	10158

2.3. Улсын бүртгэлийн хэлтэс

№	Заалт	Биелэлт
1.	Иргэдийн баримт бичгийн зөрчлийн арилгат хувь	99,9
2.	Шилжих хөдөлгөөн хот /шилжиж ирсэн/	7
3.	Шилжих хөдөлгөөн аймаг, сум хороонд, /тоо/	51
4.	Гадаад паспорт эзэмшигчдийн тоо	4812

5.	Шинээр гэрлэлт /тоо/	538
----	----------------------	-----

ГУРАВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

3. Эрүүл мэндийн чиглэлээр

3.1. Эмнэлгийн тусламжийн чиглэлээр

Нярайд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор ЭМЯ-ны гаргасан удирдамжийн дагуу 2 хоногийн сургалтыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн нярайн зөвлөх эмч, клиникийн профессор тус аймагт зааж явуулсан. Уг сургалтыг “Нярайн амьсгал, зүрхний гачаалд үзүүлэх яаралтай тусламж”, “Нярайд зонхилон тохиолдох эмгэгүүд”, “Нярайн сурфактант эмчилгээний зарчим, хэрэгжилт” сэдвүүдээр явуулж, сургалтад аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх болон Хүүхдийн тасаг, сум, өрхийн Эрүүл мэндийн төв болон Сум дундын эмнэлгийн хүүхдийн эмч, нярайн эмч, сувилагч, эх баригч, багийн эмч нар нийт 50 гаруй эмч, мэргэжилтнүүд хамрагдлаа.

“Сувилахуйн тусламж, үйлчилгээнд хамтын оролцоо” сэдэвт бүсийн сумдын эрүүл мэндийн байгууллагуудын уулзалт, ажил мэргэжлийн уралдаан, спортын тэмцээнийг Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвд 2019 оны 9 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулав. Тус уулзалт, уралдаан, тэмцээнд Цэнгэл, Ногооннуурын Сум дундын эмнэлэг, Улаанхус, Сагсай, Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч, багийн бага эмч, сувилагч, эх баригч нар оролцож нийт 50 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдав.

3.2. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр

Улаанхус суманд вируст А гепатитын өвчлөл бүртгэгдсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргаар ахлуулсан 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг очиж сумын ЗДТГазар, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвд ажиллаж, сургуулийн багш, ажилчин 46 хүн, цэцэрлэгийн багш ажилчин 23 хүн, Эрүүл мэндийн төвийн эмч ажилчин 15 хүн, нийт 84 албан хаагчид аймгийн хэмжээнд бүртгэгдсэн БЗДХ-ын өнөөгийн байдал, А гепатитын халдварын талаар мэдээлэл өгч, элэгний В, С вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, илрүүлэх үзлэг шинжилгээнд хамрагдахын ач холбогдлын талаар ойлголт өглөө. Сургууль, цэцэрлэгийн гар угаах нөхцөл байдалтай танилцаж, удирдлагуудад хүүхдийн гар угаах орчин нөхцөлийг сайжруулан хүүхэд бүрт гар угаахыг хэвшүүлэхийг үүрэг болголоо.

2019 оны 9-р сарын 16-ны өдөр аймгийн ЭМГ-ын НЭМТөвийн даргаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй баг Дэлүүн сумын Сум дундын эмнэлгийн бэлэн байдал, Сумын Засаг даргаар ахлуулсан эрүүл мэндийн салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцах, ард иргэдэд сэрэмжлүүлэг өгөх зорилгоор 1 өдөр ажиллаа. Тус сумын удирдлагатай уулзаж тарваган тахлын нян 2 багаас гарсантай холбоотой арга хэмжээ хэрхэн авч байгаатай танилцаж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллав.

Мөн уг ажлын хэсэг Дэлүүн сумын төвд ажиллаж Тарваган тахал өвчнөөс сэргийлэх, А гепатитын халдвараас сэргийлэх, угаарын хийн хордлогоос сэргийлэх, Элэг бүтэн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар ард иргэдэд мэдээлэл өгч өдөрлөг зохион байгуулж, 450 хүнийг хамруулсан.

Улаанхус сумын Хөх хөтөл, Согоог багуудад 2019 оны 9-р сарын 4-ний өдөр НЭМТөвийн даргаар ахлуулсан ажлын хэсэг 1 өдөр ажилласан бөгөөд Хөх Хөтөл

багийн сургуулийн Нийгмийн ажилтан, Сургуулийн эмч нартай уулзаж, сургуулийн анги тус бүрт гар угаах орчин бүрдүүлэх, халдваргүйтгэлийн бодисыг хэрэглэх заавраар хангасан.

А хепатитын халдвараас сэргийлэх зорилгоор мэдээлэл, сургалт сурталчилгааг орон нутгийн радио болон “Саян”, “Дербес” ТВ-ээр давтамжтайгаар дамжуулан эмчийн зөвлөгөөг хүргүүлсэн.

Энэ сард Улаанхус сумын Хөх хөтөл багт А гепатит өвчний 4 тохиолдол шинээр бүртгэгдсэн гэсэн статистик мэдээ, мэдээллийн дагуу 2019 оны 9-р сарын 24-ний өдөр НЭМТөвийн дарга Е.Саулегээр ахлуулсан ЭМГ-ын мэргэжилтнүүд тус багт ажиллаж шинээр бүртгэгдсэн 4 тохиолдолд хавьтлын судалгаа хийж, 4 тохиолдлын 400 м.кв талбай бүхий байшинд халдваргүйжүүлэлтийг 3%-ийн жавелионы уусмалаар хийсэн. Мөн ариун цэврийн байгууламж болон гар угаах нөхцөлийн талаар судалгаа хийсэн. Шинээр бүртгэгдсэн 4 тохиолдол нь гар угаах нөхцөл бүрдсэн боловч, ариун цэврийн байгууламж эрүүл ахуйн стандартын шаардлага хангаагүй, эцэг эхийн гар угаах, халдварт шар өвчний талаарх мэдлэг дутмаг байсантай холбоотой үүссэн гэдэг нь тогтоогдсон.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4. Дэд бүтцийн чиглэлээр

4.1. Цахилгаан хангамжийн талаар

Аймгийн хэмжээнд Баруун бүсийн эрчим хүчний системээс 18454.8 мян.кВ.цаг цахилгааныг худалдан авч, 15682.8 мян.кВ.цаг цахилгаан худалдан борлуулсан. Нийт 2772.0 мян.кВ.цаг цахилгааныг шугамд алдсан. Нийт алдагдал 15.02%-тай байгаа. Худалдан борлуулсан цахилгаанд 2014.6 сая төгрөгийн нэхэмжлэл бичиж, 1996.4 сая төгрөгийг цуглуулсан. Борлуулалтын орлого 99.1%-ийн цуглуулгатай байна.

4.2. Холбооны талаар

Тус газар нь 2019 оны 9 дүгээр сард шуудангаар болон мэйл хаягаар компаниас 2, орон нутгийн бусад байгууллагаас 3, нийт 5 албан бичгийг хүлээн авч тухай бүр бүртгэл хөтлөн, байгууллагын удирдлагад танилцуулан холбогдох албан тушаалтнуудад шилжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Мөн газрын үйл ажиллагааны асуудлуудаар албан байгууллагад 4 албан бичиг боловсруулан хүргүүлж хариу, шийдвэр гаргуулж ажиллав.

Улс, хот хоорондын сүлжээний бэлэн байдлыг хангаж, орон нутгийн иргэд, албан байгууллагууд мэдээ, мэдээллийг цаг тухай бүр, шуурхай хүлээж авах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд онцгой анхаарч аймаг, сумын шилэн кабель, кабель шугамын үзлэг, үйлчилгээг тогтмол чанартай хийж, гарсан гэмтэл саатлыг шуурхай илрүүлэн засаж, зөрчлийг арилгах арга хэмжээг байнга авч ажилласны дүнд сүлжээнд саатал гараагүй болно. Тайлант сард үндсэн SDH төхөөрөмжөөс ямар нэгэн гэмтэл саатал гараагүй болно.

4.3. Аймгийн радио телевизийн сүлжээний ажлын талаар

Дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.

Аймгийн 3 тоон телевиз болон радио ФМ-ийг Монсатын системд бүрэн шилжүүлсэн.

Радио болон Тоон ТВ-ийн станцуудын ажиллагааны талаарх мэдээ, тооцоог үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад хүргэж ажиллав.

4.4. Усны талаар

Аймгийн “Файн-Ноос” ХХК болон “Суат” ХХК-ийн бохир усны шугамыг нийлүүлж байгаа бөгөөд бохир уснаас дээж авч химийн шинжилгээ хийв.

НААҮ-ний “Суат” ХХКомпаний Ус шинжилгээний лабораторид ашиглаж байгаа химийн их хортой болон аюултай бодисыг ашиглах, хадгалах үйл ажиллагаатай холбоотой гарч болзошгүй аюулын үед ажиллах төлөвлөгөөг гаргаж, аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлж батлуулан мөрдөж ажиллаж байна.

Ундны усны шинжилгээг өдөр бүр хянаж, шинжилгээг хийж байна.

Цэвэр, бохир усны гол магистрал шугамын худгуудыг цэвэрлэж бүгдийг нь тагтай болгов.

4.5. Авто тээврийн талаар

Орон нутгийн хөрөнгөөр “Өлгий-Хашаатын” чиглэлд шинээр пост барихаар зураг төсөв нь гарч барилгын ажил эхэлсэн. Өлгий-Хашаатын чиглэлд барих постын зам талбайн өндөр хүчдэлийн станц, зам ашигласны төлбөр хураах цех, жин хэмжүүрийн пүү барих ажил 2019 оны төлөвлөгөөт төсөвт тусгагдсан болно.

Энэ сард техникийн хяналтын үзлэгт нийт 578 тээврийн хэрэгсэл хамаарагдсанаас суудлын тээвэр 402, ачааны тээвэр 89, автобус 13, тусгай 0, механизм 0, чиргүүл 8, мотоцикл 65 тус тус бүртгэгдсэн байна. Нийт өссөн дүнгээр тэнцээгүй тээврийн хэрэгсэл 0 бүртгэгдсэн.

Улс хоорондын Өлгий-Алмата хотын чиглэлд орчин үеийн АЕРО, ЮТИОНГ том оврын автобуснуудаар зорчигч тээвэрлэх, шинээр рейс нээх ажлууд явагдаж байна.

Хот хоорондын чиглэлд “Газрын Од” ХХК-ийн том оврын 24 АЕРО автобус, “Цэнгэлтранс” ХХК-ийн том оврын 15 АЕРО автобус, нийт 39 тээврийн хэрэгслээр хот хоорондын байнгын үйлчилгээнд зорчигч тээвэрлэж байна.

Энэ сард хот хооронд явсан зорчигчдын тоо 3240, рейсийн тоо 72 байна. Нийт Казахстан улс руу автобусаар явсан зорчигчдын тоо 360, рейсийн тоо 8 байна.

ТАВ. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР

1. БУЛГАН СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

9 дүгээр сард хийхээр төлөвлөсөн ажлын биелэлтийг гаргаж, 10 дугаар сард хийх ажлаа төлөвлөж байна.

Энэ сард сумын ЗДТГ-ын ихэнх ажилтнууд ээлжийн амралтаа эдэлж дуусаад ажилдаа орсон.

Сумын бүх иргэд, айл өрх, албан байгууллагууд өвөлжилтийн бэлтгэл ажлаа хангасан.

Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргаар ахлуулан тус суманд ажиллаж, сумын өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцан 80-иас дээш хувьтайгаар дүгнэсэн.

Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Сумын 9 дүгээр сарын санхүүжилт гүйцэд ирээгүйгээс төсөвт байгууллагуудын санхүүжилтийн сарын тайлан гараагүй. Сумын татварын улсын байцаагч Улаанбаатар хотод сургалтад хамрагдаж байгаа тул орон нутгийн орлогын талаар тодорхой мэдээлэх боломжгүй байна.

Гурав. Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд

Сумын хэмжээнд ногоон өвс 4100 тн, гар тэжээл 380 тн бэлтгэж аймгаас ирүүлсэн төлөвлөгөөг давуулан биелүүлсэн. 2019 онд хөрш аймгийн нутагт 440 өрхийн 65682 толгой мал, өөрийн аймаг болон бусад сумдын нутагт 89 өрхийн 13719 толгой мал, улсын тусгай хамгаалалттай газар нутагт 240 өрхийн 31500 толгой мал өвөлжих тооцоо гарч байна. Нийт отроор 769 өрхийн 110901 толгой мал оторлон өвөлжих юм.

Дөрөв. Үйлдвэрлэл, үйлчилгээ, эрчим хүч, дэд бүтцийн бодлогын хүрээнд

Энэ сард сумын хэмжээнд цахилгаан, эрчим хүч тасалдаагүй хэвийн ажилласан. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх дэд бүтцийн ажлууд хийгдэж дууссан. Аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 150 сая төгрөгийн Улаагчны замын засварын ажил болон сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 200 сая төгрөгийн сумын төвийн гудамжны авто замын ажлыг аймгийн “Гранд роуд” ХХКомпани хийж гүйцэтгэсэн.

Тав. Эрүүл мэнд, спортын талаар

9 дүгээр сард Эрүүл мэндийн төвд 5 эх амаржиж, 5 хүүхэд эсэн мэнд бойжиж байна. 5 эхийн төрөхийн ор хоног 30 ор хоног байна. Хяналтад 78 эх байгаа ба нас баралт 1 гарснаас эмэгтэй иргэн гэрт өвчний улмаас нас барсан. Хүүхдийн эндэгдэл гараагүй. Эрүүл мэндийн төвд нийт 59 хүн хэвтэн эмчлүүлсний ор хоног 360 ор хоног байна. Халдварт бус өвчлөл 36 гарсан ба түргэн тусламжийн дуудлага 81 гарснаас 69 нь алсын дуудлага байв. Үзлэг бүгд 658 байснаас, урьдчилан сэргийлэх үзлэгт 156, амбулаторын үзлэгт 412 хүн тус тус хамрагдсан. Вакцинжуулалтад 127 хүүхэд хамрагдсан байна. Сумын эрүүл мэндийн төвийн ажил хэвийн явагдаж байна.

Зургаа. Боловсрол, соёл, шинжлэх ухааны талаар

Сумын 3 сургууль, 2 хүүхдийн цэцэрлэг 9 дүгээр сарын 2-ноос эхлэн 2019-2020 оны шинэ хичээлийн жилийг эхлүүлсэн. Улсын хөрөнгө оруулалтаар тус сумын Ёлтын бага сургуулийн 1,7 тэрбум төгрөгийн барилгын цогцолбор ашиглалтад орж, тус сургууль байгуулагдсаны 80 жилийн ойг өндөр зохион байгуулалттайгаар тэмдэглэн өнгөрүүлсэн. Сумын 3 сургуулийн 52 бүлэгт 1000 гаруй хүүхэд хичээллэж, 300 хүүхэд дотуур байранд амьдарч байна. Сумын 1, 2-р хүүхдийн цэцэрлэгийн 6 бүлэгт 150 орчим хүүхэд хүмүүжигдэж байна. Бүх сургууль цэцэрлэгүүд өөр өөрсдийн сургалтын хөтөлбөрийнхөө дагуу хичээллэж байгаа ба өвлийн бэлтгэлээ бүрэн хангасан хэвийн үйл ажиллагаа явуулж байна.

2. ТОЛБО СУМ

Нэг. Удирдлага зохион байгуулалт, хууль, эрх зүйн чиглэлээр

9 дүгээр сарын 3-ны өдөр сумын Засаг даргын Тамгын газрын бүх ажилтан, албан хаагчдын хуралдааныг хийж, ажлын төлөвлөгөө гаргав.

Хоёр. Боловсролын талаар

Сумын ЕБС-ийн 2019-2020 оны хичээлийн жилийн нээлтийн арга хэмжээг 9 дүгээр сарын 1-ний өдөр сумын удирдлагууд, сургуулийн нийт багш, эцэг эх, сурагчдын хамт хийв.

Сургуулийн 80 жилийн ойн баярыг төлөвлөгөөний дагуу ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэв. Ойн баярыг угтаж ахмад багш нарын нэрэмжит кабинетийг төрөл садан, төгсөгчид хамтран шинээр байгуулсан.

Тус сургууль нь Дэлхийн Зөн ОУ-ын байгууллагын тусламжаар 70 ширхэг ширээ, сандлаар шинээр хангагдав.

Хичээлийн жилийн эхэнд сургуулийн захирал, багш, нийгмийн ажилтан нар “Сайжруулсан хөтөлбөрийн” сургалтад хамрагдав.

Мөн сургалтын менежерүүдийн багш нарт үзүүлэх дэмжлэг, манлайлал сургалтад менежерүүдийг хамруулав.

Хичээлийн жилд хэрэглэх ном, сурах бичгийг татан авч сурагчдад тарааж өгсөн.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр

Энэ сард нийт 35 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн ба нийт үзлэг 1012, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 230 байна.

Хөхний үзлэг 95, эсийн шинжилгээнд 9 хүн тус тус хамрагдсан. Элэгний урьдчилан сэргийлэх үзлэгт 48 хүн орсон. Нийгмийн даатгалаас өгөх үнийн хөнгөлөлттэй эмийг 31 хүнд өгсөн ба элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээнд 262 хүнийг хамруулав.

Цусны ерөнхий шинжилгээнд 26 хүн, шээсний ерөнхий шинжилгээнд 41 хүн, ДОХ, тэмбүүгийн шинжилгээнд 10 хүн, элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд 30 хүн, сахар тодорхойлох шинжилгээнд 34 хүн, цусны бүлэг тодорхойлох шинжилгээнд 9 хүн тус тус хамрагдсан.

Алсын дуудлагад 22 удаа, ойрын дуудлагад 33 удаа явж ард иргэдэд үйлчилсэн.

3. ДЭЛҮҮН СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Байгууллагын удирдлагуудын хуралдааныг хоёр долоо хоногт 1 удаа хийж, цаг үеийн асуудлуудын талаар хэлэлцэн ажиллаж байна.

Хадлан, тэжээл бэлтгэх ажлыг товлосон хугацаанд зохион байгуулж өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэн ажилласан.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсөвт байгууллагуудад 9-р сард хүлээн авсан санхүүжилтийг хөтөлбөр, зориулалтын дагуу хуваарилан олгосон. ЕБС-ийн хувьд түлш, халаалтын өртэй гарсан ба цалингийн зардал дутуу батлагдсан учир цалин болон НДШ, ХХОАТ өр гарч байна.

Төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарт анхан шатны баримтын бүрдүүлэлт болон аж ахуйн нэгжүүдээс нийлүүлж буй бараа материал, түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнүүдийн үнийн ханш, суутгаж буй татварын талаар зөвлөгөө өгч ажиллав.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төлөвлөгөөг “Шилэн дансны” систем, дундын сүлжээнд байршуулав.

Аймгийн Статистикийн хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийг сайжруулах талаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Багийн өрхүүдийг өрх бүрээр байршлыг нь тодорхойлж, хашаа хаалганы дугаарыг шинэчлэн дугаарлаж ажиллав.

Сумын хүн ам, өрхийн бүртгэлийн программыг сар бүр хөтөлж төрсөн хүүхэд, нас барсан иргэдийн мэдээлэл, шилжиж ирсэн, шилжиж явсан иргэдийн мэдээллийг тухай бүр оруулж байна.

Бүх төрлийн татварыг хурааж, нэр төрлөөр нь тооцоо хийж ажилласан.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Энэ сард сумын хэмжээнд гэмт хэрэг 1 бүртгэсэн ба захиргааны зөрчил 2 гарсан байна.

Сумын нийт иргэдэд тарвага агнахгүй байх, иргэн бүр сонор сэрэмжтэй байхыг багийн Засаг дарга нараар сонордуулан ажиллаж байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Сумын төвийн Ерөнхий боловсролын 1, 2, 3-р сургуулиуд, хүүхдийн цэцэрлэг болон Сум дундын эмнэлгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа болно.

Сумын хүүхдийн цэцэрлэг, ахлах сургуулийн үйл ажиллагаатай танилцаж хүүхдийн ирц болон дотуур байрны хүүхдийн амьдарч байгаа орчинтой танилцаж, 2 удаа хяналт тавьж ажилласан.

Сум дундын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч 42 ,ор хоног 286, үзлэгт 995, төрөлт 6, нас баралт 1 хүн, 0-3 насны хүүхдийн эндэгдэлгүй ажиллаж байна. Вакцинжуулалтын хамрагдалт 92,3 %-тай байна.

9-р сарын 30-ны байдлаар Дэлүүн сумын Нийгмийн даатгалын сангаас 915 тэтгэвэр авагч иргэнд 280,755,229 төгрөгийн тэтгэвэр, 4,563,557 төгрөгийн тэтгэмж олгогдсон байна.

Шинээр өндөр насны тэтгэврийн болзол хангасан 35 хүний тэтгэврийг тогтоолгож, 85 хүний ХЧТАТэтгэвэрийн хугацааг сунгуулан 3 хүнд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгохоор материалыг хүлээн авч аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэв.

Тав. Хөдөө, аж ахуйн бодлогын хүрээнд

2019 онд сумын хэмжээнд 3361 тн хадлан тэжээл, 655 тн гар тэжээл, 750 тн хужир бэлтгэсэн ба сумын тэжээлийн аюулгүйн нөөцөд 30 тн өвс бэлэн байгаа болно.

Өвөлжилтийн бэлтгэл хангуулах тухай аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө гаргаж батлуулан, хэрэгжүүлж ажилласан.

Сумын хэмжээнд 2019-2020 оны өвлийн улиралд 234736 толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 392000 толгой мал өвөлжих тооцоо гарч байна.

Сумын хэмжээнд 12 багийн 960 гаруй богийн хээлтүүлэгчийг эх сүргээс ялган суурилж, тарга хүч авахуулан мал эмнэлэг, үржлийн үзлэг, хянан баталгаажуулалтад бүрэн хамруулсан.

Энэ онд сумын хэмжээнд 593 өрхөд ноосны урамшууллын падаан бичигдсэн ба падааныг заасан хугацаанд аймгийн ХХААГ-ын холбогдох албанд хүргүүлэн ажиллав.

Сум хөгжүүлэх сангийн дансанд 2019 оны 9 дүгээр сарын байдлаар 1 сая төгрөг хуримтлагдаж байна.

Сумын газар тариалангийн талаарх мэдээ тайланг цаг тухайд нь холбогдох дээд газарт хүргүүлж ажиллав. Энэ онд сумын хэмжээнд нийт 1,5 га-д төмс, 0,4 га-д хүнсний ногоо, 8,0 га-д малын тэжээл тариалан арчилж, 14 тн төмс, 1,3 тн хүнсний ногоо, 24 тн малын тэжээл хураан авсан.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 01/338 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор сумын Засаг даргын захирамжаар байгуулсан хяналт-шалгалт хийх ажлын хэсэг баталсан удирдамжийн дагуу тус суманд үйл ажиллагаа явуулж буй сургууль, “Үүдийн цай” хөтөлбөрийг хариуцагч аж ахуйн нэгж, цэцэрлэг, эрүүл мэндийн төвийн агуулах, гал тогооны ажил үйлчилгээний ариун цэвэр, хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлт, түгээлт, мөн нийтийн хоолны газрууд, гуанз, баар, хүнсний дэлгүүрүүдийн хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтад сар бүр хяналт-шалгалт хийж ажиллав.

Усны тухай хуулийн 7.3-т заасны дагуу тус сумын гадаргын усны тооллогыг сумын удирдлагуудтай хамтран зохион байгуулж, тайланг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.

Тус сумын иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх талаар өгсөн хүсэлтийг нь тухай бүр шийдвэрлүүлэн ажиллаж байна.

Шинээр 2 хүүхдийн цэцэрлэгийн барилгын засвар хийгдэж үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон. Мөн Дэлүүн сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн барилгаа шинээр баригдаж ашиглалтад орсон.

4. САГСАЙ СУМ

Нэг. Удирдлага зохион байгуулалт, хуул, эрх зүйн бодлогын хүрээнд

2019-2020 оны шинэ хичээлийн жилийн нээлтийн үйл ажиллагааг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, суралцагчдын дунд олон төрлийн уралдаан тэмцээн явууллаа.

Монгол Улсын Их, дээд сургуульд элсэгчдэд зориулж сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, зээл олгох тухай баталсан Засгийн газрын 71, 111 дүгээр тогтоолуудыг ард иргэдэд сурталчлан, сумаас шинээр элсэгчдэд бичиг баримтыг бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэн ажиллав.

Үндэсний архивын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн Төрийн удирдлагын газрын дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга болон Архивын тасгийн дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийн Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ээлжит улсын үзлэгт хамрагдаж, хангалттай сайн үнэлэгдлээ. Ажлын хэсгээс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Бүх багийн иргэдийн Нийтийн хурлыг зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумын нутаг дахь хилийн зурваст орших газруудад /Ямаат, Сонгинот/ мал оторлуулах гурвалсан гэрээ /сумын Засаг дарга, хилийн 0115 дугаар салбарын захирагч, малчин хооронд/ байгуулан малыг намрын оторт гаргасан.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах талаар сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө гаргаж бүх байгууллага, багуудад үзлэг, хяналт-шалгалт хийж, дүгнэж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар сумын Засаг даргын хугацаат албан даалгаврыг төсөвт байгууллага бүрт хүргүүлэн биелэлтийг хянаж ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх талаарх 55 дугаар хугацаат үүрэг, Статистикийн хэлтсийн Хүн ам, өрхийн мэдээллийн санг сайжруулах тухай албан бичгийн дагуу бүх багийн Засаг дарга нарт хугацаат үүрэг чиглэл өгч хэрэгжилтийг тооцож ажиллав.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2019 оны 9/112 дугаар Цэргийн ээлжит татлага явуулах тухай албан бичгийн дагуу бүх багийн Засаг дарга нарт үүрэг чиглэл өгч, сумд цэрэг татлагын ажлыг зохион явуулах бэлтгэл хангаж байна.

Долоо хоног бүрийн даваа гарагт өглөөний шуурхай зөвлөгөөнийг тогтмол явуулан төсөвт байгууллагууд болон төрийн албан хаагчдын хийсэн ажлыг авч хэлэлцэн, дараагийн 7 хоногийн ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих сумын төвийн хатуу хучилттай замын ажлыг эхлүүлсэн ба гүйцэтгэгч Гранд Роүлд компанид байгалийн дагалдах баялаг ашигласны төлбөрт 2,000,000 төгрөг бичиж нэхэмжилсэн.

Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих Дотуур байрны зөөлөн эдлэл төслийн нийлүүлэгчийг сонгох үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажлыг зохион байгуулж байна.

Нотариатын үйлчилгээг 73 иргэнд үзүүлж, тэмдэгтийн хураамжид 118,200 төгрөг оруулав.

Иргэдээс ирсэн 23 төрлийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, барагдуулах ажил зохион байгуулав. Ирсэн 21 бичгийг бүртгэж түүний мөрөөр ажил зохион байгуулж, 19 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлэв. 15 төрлийн хугацаат албан бичгийг хүлээн авч түүний мөрөөр ажил зохиож хариуг хугацаанд хүргүүлэв.

Сум дахь Улсын бүртгэлийн системийг онлайн сүлжээнд холбож, иргэний бүртгэлийн бүх төрлийн лавлагааг сумаас гарган өгч байна. Сумын иргэний бүртгэлд шинээр төрсөн 15, гэрлэсний 3, үрчилсний 1, иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд 12, шилжин ирсэн 2, шилжин явсан 3, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн ҮХХ-ийн бүртгэлд 4, газар өмчлөх бүртгэлд 5, нас барсны бүртгэлд 2, иргэний үнэмлэх захиалсан 0 тус тус бүртгэж, 15 иргэнд шинээр цахим үнэмлэх олгож, нийт 63 иргэнд Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэв.

Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсөвт байгууллагуудад 9 дүгээр сарын төсөв бүрэн ирснийг холбогдох зардлын зүйл ангиудад хуваарилан зарцуулсан.

9 дүгээр сард төсөвт байгууллагуудад 171,515,172 төгрөгийн 143 төрлийн гүйлгээ хийгдсэн. Мөн 1,143,413 төгрөгийн татварын орлогыг оруулав.

Гурав. Хөдөө аж ахуй, газар тариалан, байгаль орчны бодлогын хүрээнд

Эцэг малын бруцеллёзын тандалт шинжилгээнд бүгд 1109 толгой малыг хамруулсан.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 5 төрлийн арга хэмжээнд нийт 67037 толгой мал хамрагдсан. Үүнээс: Бруцеллёзын вакцинжуулалтад 3096 толгой тугал, 38606 толгой хурга, 17195 ишиг, бүгд 58897 толгой төл мал, Сахуугийн вакцинд 981 толгой адуу, 331 толгой унага, бүгд 1312 толгой, тугалын иж балнад вакцинд 515 толгой тугал, Цусан халдварын вакцинд үхэр 1256, 5057 толгой бог мал тус тус хамрагдлаа.

3 дугаар улирлын байдлаар мал амьтны 5 төрлийн өвчнөөр 40 толгой мал өвчилж, 6 толгой мал үхсэн ба 34 толгой мал эдгэрсэн.

Ургац хураалтын эцсийн мэдээгээр төмс 260 тн, хүнсний ногоо 53 тн, чацаргана 11 тн, малын тэжээл 110 тн хурааж авсан. Мөн хадлангийн эцсийн мэдээгээр өвс 4300 тн, гар тэжээл 300 тн, хужир давс 580 тн хурааж авлаа.

9 дүгээр сард Сум хөгжүүлэх санд 1.3 сая төгрөгийн зээл эргэн төлөгдсөн.

Дөрөв. Боловсрол соёл, шинжлэх ухааны талаар

2019-2020 оны шинэ хичээлийн жилийн нээлтийн үйл ажиллагааг хийж, хичээлийн жилийн зорилго, зорилтуудыг тодорхойлж, сургууль, цэцэрлэгт хүүхэд элсүүлэх ажлыг зохион байгууллаа. Хүүхдийн цэцэрлэгийн 9 бүлэгт 225 хүүхэд хамрагдахаас одоогоор 263 хүүхэд хамрагдсан.

Хуучин цэцэрлэгийн барилгын засварыг дотоод нөөц бололцоог ашиглан хийж, 2 бүлэг үйл ажиллагаа явуулж байна.

Багш нарын сурган хүмүүжүүлэх зөвлөлийн хурлыг хийж, хичээлийн жилийн зорилго, зорилт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг хэлэлцэн баталж БСШУСЯ-ны сайдын 2018 оны А/476 тоот тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг багш бүрт танилцууллаа.

Бэлтгэн нийлүүлэгчидтэй хийсэн бүх гэрээг шинээр байгуулж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын удирдамж гарган тусгай төлөвлөгөөний дагуу ажил зохион байгууллаа.

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас хуваарилагдсан ном, сурах бичгийг цаг тухайд нь татаж авч, сурагчдад тараан өгч байна. Одоогийн байдлаар эмзэг бүлэг болон бага, дунд, ахлах ангийн сурах бичгийг тарааж өгсөн. Сурах бичгийн хангалт өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад хангалтгүй түвшинд байна.

“Үдийн цай” хөтөлбөрийн хяналтын зөвлөлийг эцэг эх, багш, эмч, сургалтын менежерийн бүрэлдэхүүнтэй байгуулж өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллаж байна.

Тав. Эрүүл мэнд, спортын талаар

Тус сард сумын Эрүүл мэндийн төвд 1 эх хөнгөрсөн ба эмнэлэгт 53 хүн 386 ор хоног хэвтэж эмчлүүлсэн. Вакцинжуулалтад 72 хүн хамрагдаж одоогоор 69 жирэмсэн эх хяналтад байна. Эх, хүүхдийн эндэгдэл гараагүй. 65 удаа түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлсэн.

Зургаа. Нийгмийн халамж, хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаар

Нийгмийн халамжийн сангаас шинээр тэтгэвэр тэтгэмж тогтоолгох, нөхцөлт мөнгөн тэтгэмжид хамрагдахаар иргэдийн ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэв. Үүнд: Алдарт эхийн 1 дүгээр зэргийн одонд 8, 2-р зэргийн одонгийн мөнгөнд 18 эхийг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт тусламжид 13 иргэнийг, жирэмсний болон цалинтай ээжийн тэтгэмжид 38 эхийг, тэжээгч алдсаны тэтгэвэрт 1 иргэнийг, байнгын асаргаа шаардлагатай иргэний нөхцөлт мөнгөн тэтгэмжид хөгжлийн бэрхшээлтэй 3 хүүхдийг Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу тус тус хамруулав.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэгээр суманд хэрэгжсэн төмс, хүнсний ногоо тариалах хөтөлбөрт доогуур амьжиргаатай 18 өрхийг хамруулж, 5 тн төмс, 500 кг нарийн ногоо хураан авч өрхийн хүнсний хэрэгцээг хангахад тус боллоо.

Сумаас 103 өрх хүнсний эрхийн бичгийн хөтөлбөрт хамрагдсан.

Ажил идэвхтэй хайж буй 18 иргэнийг LMIS программд шинээр бүртгэж, мэргэжлийн чиг баримжаа өгсөн ба тухайн сард 12 иргэн түр ажлын байраар хангагдлаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2017 онд Малжуулах зориулалтаар олгогдсон 2 сая төгрөгийн зээлийг эргэн төлүүлэв.

5. АЛТАЙ СУМ

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэд аймгийн Засаг дарга болон сумын Засаг даргын захирамжийн дагуу ажлыг шуурхайлан зохион байгуулж, сумын ЗДТГазраас хяналт тавьж ажилласан.

Энэ сард сумын Засаг даргын 10 захирамж гарч тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэн биелэлтэд хяналт тавьж ажиллав.

Дээд газраас болон аймгийн ЗДТГ-аас 141 албан бичиг ирж цаг тухайд нь холбогдох албан тушаалтнуудад цохолт хийж хэрэгжилтийг хангуулсан.

Мөн сумын Засаг даргын Тамгын газрын даргын 7 тушаал гарч, 6 албан тоот, сумын Засаг даргаас 13 албан тоотыг холбогдох газруудад явуулсан ба бүртгэлийн дэвтэр хөтөлж боловсруулсан, нийлсэн, хянасан стандартыг мөрдөн ажиллаж байна.

Иргэний 12 төрлийн бүртгэлийг өдөр бүр хөтлөн явуулж зохих хууль журмын дагуу гэрчилгээ олгож байна. 9 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар шинээр төрсөн 7 хүүхдэд төрсний гэрчилгээ олгож баримтжуулав. Тухайн сард шинээр гэрлэсэн 2 хосыг гэрлэлтийн бүртгэлд бүртгэв.

Хоёр. Хөдөө аж ахуй, байгаль орчны талаар

Мал эмнэлгийн үржлийн нэгжээс 8 төрлийн маягтын дагуу мэдээг авч нэгтгэн графикт хугацаанд гаргаж аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэв.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5,0 сая төгрөгөөр хогийн сав хийлгэж тогтоосон цэгүүдэд байршуулав.

Ан амьтан ялангуяа аргалын намаржилтын байдалд ажиглалт судалгаа хийж зоон, нуруу газруудаар бэлчээрлэж байгааг тогтоон ажиллав. Аргалын тооллогыг хийхэд 9 дүгээр сарын байдлаар Халуунд 53 аргаль, угалз, 6 хурга, Шарговьд 17, Даваатад 18, Цалгарт 8 аргаль, 5 угалз зусч байгаа болно.

Гурав. Газар зохион байгуулалтын талаар

Сумын нутаг дэвсгэрт газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын газрын төлбөрийг хуулийн дагуу ногдуулж сумын төсөвт төвлөрүүлж байна.

Шинээр газар эзэмшүүлэх 4 өргөдөл, газрын маргаантай 1 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч бүртгэн өвөлжөө, хаваржааны зориулалтаар 3 иргэний эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх сумын Засаг даргын захирамжийг үндэслэн газар эзэмших гэрээ байгуулж гэрчилгээ олгов.

Энэ сард 11 иргэний нэгж талбарын хувийн хэргийг ЛМ2 программд оруулан цахимд архивлав.

Эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ авахыг хүссэн 2 хүний материалыг бүрдүүлж, кадастрын зургийг хянан баталгааны дүгнэлт хийж, аймгийн Үл хөдлөх хөрөнгийн газарт хүргүүлсэн.

Дөрөв. Боловсролын талаар

Сумын 1 дүгээр ЕБСургууль нь түүхт 60 жилийн ойн баяраа тэмдэглэн өнгөрүүлэв. Сургуулийн сурагчдын хамрагдалт 80 хувьтай байгаагаас, 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалт 60 хувьтай байна.

Хүүхдийн цэцэрлэг нь сургалтын үйл ажиллагаагаа эхэлж сургалтын сайжруулсан хөтөлбөрийн дагуу хичээл сургалтыг явуулан СӨБоловсролын хамрагдалт 100 хувьтай байна. Мөн Хилийн цэргийн заставт цэцэрлэгийн бүлгийг шинээр нээж ажиллуулж байна.

Хүүхдийн цэцэрлэг нь өвөлжилтийн бэлтгэлээ хангаж байгаа бөгөөд одоогоор нүүрс түлээгээ татан авч, хүнс, хүнсний ногоог 10-р сард бэлтгэн авах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Өвөлжилтийн бэлтгэл ажил 90 хувьтай хангагдав.

Тав. Эрүүл мэндийн талаар

0-5 насны хүүхдийн хяналтын чанарыг сайжруулах, өртөмтгий эмзэг бүлгийн эх хүүхдийг идэвхтэй эргэлтэд хамруулах, эмчлэн эрүүлжүүлэх ажил хийгдсэн бөгөөд жирэмсний хяналтад шинээр 3 эхийг авсан ба одоо хяналтад 38 эх байна.

Өртөмтгий эмзэг бүлгийн жирэмсэн эхийн тоо 12 байна. Жирэмсэн болон төрсөн эхэд 54 удаа гэрийн идэвхтэй эргэлт хийсэн.

Жирэмсэн эхчүүдэд 1 удаа сургалт зохион байгуулсан.

6. ЦАГААННУУР ТОСГОН

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

Тосгоны захирагчийн захирамжаар томилогдсон ажлын хэсэг байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажилд хяналт-шалгалт хийв.

Төсөвт байгууллагууд өвлийн бэлтгэл ажлаа хангаж, нүүрс түлээгээ нөөцөлж авсан.

Гудамжны гэрэлтүүлгийн ажил нь 34,9 төгрөгөөр хийгдсэн. Мөн Цагааннуур хүндэтгэлийн толгойн ажил хийгдсэн ба төсөвт өртөг нь 21,3 сая төгрөг байна.

Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

1. Хилийн 0285-р анги /Үндсэн цалин/	-	236,938,500.00
2. Дунд сургууль /Үндсэн цалин/	-	35,099,300.00
3. Хүүхдийн цэцэрлэг /Үндсэн цалин/	-	15,851,606.00
4. Эрүүл мэндийн төв /Үндсэн цалин/	-	16,032,800.00
5. Соёлын төв /Үндсэн цалин/	-	4,200,500.00
6. Захирагчийн алба /Үндсэн цалин/	-	10,076,800.00
Бүгд		318,199,556.00

Гурав. Статистик мэдээний талаар

Тосгоны ард иргэд өвсийг Ногооннуур сумаас худалдан авч бэлтгэдэг ба 9 дүгээр сарын байдлаар 300тн өвс бэлтгэсэн болно.

2020 оны хүн амын урьдчилсан тооллогын ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд одоогоор тооллогын ажил 45 хувьтай байна.

Дөрөв. Боловсрол, соёлын талаар

4.1. Ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл

9 дүгээр сарын 1-нд хичээлийн шинэ жилийн нээлтийн ажиллагааг хийж багш, ажилчид болон сурагчдаа хүлээж авав.

Багш нарын цагийн тооцоог хийж, хичээлийн хуваарийг шинэчлэн гаргаж, хуваарийн дагуу сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

4.2. Хүүхдийн цэцэрлэгийн мэдээлэл

Тус хүүхдийн цэцэрлэг нь энэ сард 100 хүүхдийг хүлээн авч үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүүхдийн цэцэрлэгийн барилгад “ЛАУ ЛАУ” ХХК 42 сая төгрөгийн өртөгтэй их засварын ажлыг хийж дуусгав.

Улаанбайшинт дахь салбар бүлгийн урсгал засварыг бүрэн хийж гүйцэтгэв.

4.3. Соёлын төв

“Соёл урлагийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан аймгийн БСУГ-аас зохион байгуулж буй спортын арга хэмжээнд соёлын төвийн ажилчид оролцохоор бэлтгэл ажлаа хангаж байна.

Тусгай төлөвлөгөөний дагуу 7 хоног бүрийн Даваа, Баасан гарагуудад бага ангийн сурагчдын дунд “Чөлөөт” бүжиг, Мягмар, Бямба гарагуудад домборын дугуйланг тогтмол явуулж байна. Бүжгийн дугуйланд 25 сурагч, домборын дугуйланд 35 сурагч, нийт 60 сурагч хамрагдаж байна.

Тав. Эрүүл мэндийн талаар

ЭМГазар болон холбогдох байгууллагуудаас ирсэн хугацаат болон хугацаагүй албан бичгүүдийг хүлээн авч ажилтнуудад танилцуулж, түүний мөрөөр ажил зохион байгуулж байна.

Жирэмсэн болон өртөмтгий бүлгийн эхчүүдийг тогтмол хяналтад авч аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх тасгийн нарийн мэргэжлийн эмчид шилжүүлэн ажиллаж байна.

Сумын ЭМТөвийн шинээр баригдах барилгын газрын кадастрын зургийг хийлгэсэн.

Статистик мэдээлэл:

Бүгд үзлэг	-	371
Үүнээс: Урьдчилан сэргийлэх үзлэг	-	85
Амбулаторийн үзлэг	-	101
Гэрийн дуудлагын тоо	-	31
Алсын дуудлага	-	15
Нас баралт	-	0
Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн	-	6 хүн
Эмнэлгээс эмчлүүлж гарсан	-	7 хүн
Өдрийн эмчилгээнд хамрагдсан	-	14 хүн
Аймагт төрсөн эх	-	3
Өөрийн эмнэлэгт төрсөн	-	0
Аймагт шилжүүлсэн жирэмсэн эх	-	3
Хяналтад байгаа жирэмсэн эх	-	22
Үүнээс: Шинээр хяналтад авсан жирэмсэн эх	-	1
Дархлаажуулалтад хамрагдсан хүүхэд	-	19

Долоо. Нийгмийн халамж, хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаар

Энэ сард малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамрагдсан 4 малчинд 19 сая төгрөгөөр нэг малчинд 50-70 мал худалдан өгч дэмжлэг үзүүлэв.

Нийгмийн халамж, үйлчилгээнээс авах хүмүүсийн тэтгэвэр тэтгэмжүүдийг олгох ажлыг зохион байгуулж хиймэл шүд хийлгэсэн 1 ахмад, замын зардлын хөнгөлөлтөд 2 ахмадыг тус тус хамруулан ажилласан.

Мөн Цалинтай ээж хөтөлбөрт 5 эхийг хамруулж, жирэмсэн хөхүүл хүүхэдтэй эхийн нөхцөлт мөнгөн тэтгэмжид 4 эх нэмэгдэж бүртгэгдсэн.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР